

ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ

2013 оны Санхүүгийн Тайлан

Үндэсний Аудитын газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар
холбоо барина уу:

Аймгийн Тэргүүлэх Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

Аудитор

Ц.Саранчимэг

Утас: 70273204, 70273463

- Танилцуулга4-7
- Санхүүгийн дотоод хяналт 7
- Гол шийдлүүд 7
- Залруулаагүй алдаа 8
- Тайлбар мэдүүлгийн захидал..... 8
- Аудитын санал дүгнэлт 8

ТӨАГ-ын хаяг

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

Төв Чандмань –ДЭХГ-ын 2013 оны Санхүүгийн Тайланд
ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

1. Бид Төв Чандмань ДЭХГ-ын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Төв Чандмань ДЭХГ-ын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаах бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Төв Чандмань ДЭХГ-ын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

➤ Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан төлөвлөгөөнөөс орлого 359434.7 мянган төгрөгөөр давж зардал 201594,9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.
- Үйл ажиллагааны ашигийг 718534,2 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан ч гүйцэтгэлээр орлого давж биелэсэн болон зардал хэмнэгдсэнээс алдагдал буурч 25693,9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- 2013 оны эхэнд авлага 98241.8 мянган төгрөгөөр, өглөг 176205,3 мянган төгрөгөөр өссөн байна.
- Бараа материал 114525,7 мянган төгрөгөөр , үндсэн хөрөнгө 1194093,4 мянган төгрөгөөр өссөн байна.
- Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 12-р сарын 20-ний өдрийн 116 тоот тогтоолоор гүний 5 худаг 47097,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа.

ҮАГазрын харьяа
Аймгийн Аудитын газар
2014-03-21

Танилцуулга

1. Бид Төв Чандмань ДЭХГ-ын 2013 оны 12-р сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Төв Чандмань ДЭХГ-ын удирдлагад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Төв Чандмань ДЭХГ-ын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

2. Бидний 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Төв Чандмань ДЭХГ-ын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Төв Чандмань ДЭХГ-ын тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

1. Орлогын талаар

Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаас томилогсон УЗ-ийн 2013 оны 1 дүгээр сарын 11-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2013 оны орлогын төлөвлөгөөг цэвэр ус 169502.0 мянган төгрөг, сувагжуулалт 113459.2 мянган төгрөг, орон сууцны үйлчилгээний 62964.0 мянган төгрөг, усан сан 12999.6 мянган төгрөг, нийтийн бие засах газар 1555.2 мянган төгрөг, дулааны эрчим хүч 2753507.4 мянган төгрөг нийт 3113987.4 мянган төгрөгөөр баталжээ.

2013 онд нийт борлуулалтаар 3473422.1 мянган төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 359434.7 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар давуулсан. Орлогын төрлөөр нь авч үзвэл дулааны эрчим хүч үйлдвэрлэлтийн борлуулалтын 340985,5 мянган төгрөг, цэвэр усны борлуулалтаар 9465,7 мянган төгрөг, сувагжуулалт /бохир усны/ 5643,3 мянган төгрөг, орон сууцны засвар үйлчилгээнээс 2209,5 мянган төгрөг, гэр хороололын усан сангийн орлого 1130,7 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Борлуулалтын орлогыг ажил үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл дулааны эрчим хүч 3094492,9 мянган төгрөг, Цэвэр ус 178967,7 мянган төгрөг, Сувагжуулалт 119102,5 мянган төгрөг, Усан сан 14130,3 мянган төгрөг, орон сууц 65173,9 мянган төгрөг, нийтийн бие засах газар 1555.2 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Дулааны үйлдвэрлэлийн борлуулалт нийт борлуулалтын орлогын 3094492,9 мянган төгрөг буюу 89,1 хувийг бүрдүүлжээ. Үүний 2636359,5 мянган төгрөг буюу 85,2 хувь төсвийн байгууллагуудын халаалтын хөлс эзэлж байна. Тайлан тэнцэлд орлогоо бүрэн тусгасан байна.

Үйл ажиллагааны бус орлогоор 8600,0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 525999,6 мянган төгрөг орлого олж орлогын төлөвлөгөөг 517399,6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Энэ нь аймаг болон улсын хөрөнгө оруулалттай ажилын тендерт оролцож 493324,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалттай

холбоотой 2,3-р зуухны шинэчлэлийн ажилд 477591,3 мянган төгрөгийн зардал гарч 15732,7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2. Зардлын талаар

2013 онд дулаан үйлдвэрлэлийн орлогыг 3113987,4 мянган төгрөгөөр , зарлагыг 3784878,7 мянган төгрөгөөр удирдлагын зардлыг 47642,9 мянган төгрөгөөр үйл ажиллагааны ашигийг 718534,2 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Мөн Аймгаас алдагдал нөхөх санхүүжилт 53517,9 мянган төгрөг, үйл ажиллагааны бус орлого 8600,0 мянган төгрөг, үйл ажиллагааны бус алдагдал 7200,0 мянган төгрөг, үйл ажиллагааны алдагдал 1400,0 мянган төгрөг, нийт алдагдалыг 663616,3 мянган төгрөгөөр батласан байна. Батлагдсан төлөвлөгөөгөөр үйлдвэрлэлийн зардал 3784878,7 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 3583283,8 мянган төгрөгийн зардал гарч 201594,9 мянган төгрөгөөр зардал хэмнэсэн байна. Хэмнэсэн зардлын хувьд цалин шимтгэл 138635,9 мянган төгрөг, нүүрс 48228,6 мянган төгрөг, урсгал засвар 15928,6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Гэвч үйлдвэрлэлийн зардалд борлуулалтын болон удирдлагын зардалтай холбоотой 125227,9 мянган төгрөгийн интернет, бичиг хэргийн зардал, элэгдэл, АБӨЯХАТ, аудитын зардал газрын төлбөр, томилолт, уралдаан тэмцээн, шагнал урамшил, тэтгэмж, баяр ёслол хүлээн авалт, сургалт, семинар, зар сурталчилгаа , санхүү лицензын зардлыг хуваарилаж тооцолгүй үйлдвэрлэлийн зардал бүрэн шингээж өртөгт оруулж тооцсон байна.

3.Бараа материал

Бараа материалын дансны оны эхний үлдэгдэл 365192,3 мянган төгрөг, тайлант хугацаанд 5148725,1 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 5034199,4 мянган төгрөгийн бараа материал данснаас хасагдсаж оны эцсийн үлдэгдэл 479718,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс Дуусаагүй үйлдвэрлэлийн зардалын дансаар 3419783,3 мянган төгрөгийн бараа материал орлого авч зарцуулсан байна. Жилийн эцсийн 479718,0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлээс 286359,1 мянган төгрөгийн буюу 10668 тонн нүүрсний нөөц, 141260,2 мянган төгрөгийн ашиглалтанд байгаа тоног төхөөрөмжүүд, 51950,8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл эзэлж байна.

4.Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 7479321,7 мянган төгрөг, тайлант онд 1281393,0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 87299,6 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасагдаж оны эцэст 8673415,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нэмэгдсэн үндсэн хөрөнгө нь орон нутгийн болон улсын хөрөнгө оруулалтаар зуухны шинэчлэлийн тоног төхөөрөмж, бохир татан зайлуулах, авто машин зэрэг нэмэгдсэнтэй холбоотой байна. Хасагдсан хөрөнгийн хувьд аймгийн ИТХурлын тогтоолоор 87299,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлах шийдвэрийн дагуу хасагдсан байна.

Төв Чандмань ДЭХГ-ын захирлын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх тооллогын комиссын томилж, хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийж тооцоог бодсон байна. Жилийн эцсийн тооллогоор ашиглагдахгүй болсон 87299.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлаж данснаас хассан. Актлагдсан хөрөнгийн элэгдэл 21534,9 мянган төгрөг хасагдаж 65764,7 мянган төгрөгийн элэгдэл байгуулагдаагүй хөрөнгө хасагдсан байна. Энэ нь жил бүр элэгдэлийг стандартын дагуу байгуулж тайлагнаагүйгээс элэгдэл байгуулагдаж дуусаагүй хөрөнгө актлагдсан мэт харагдаж байгаатай холбоотой байна. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн нь гүйлгээ баланс, тодруулга, санхүүгийн тайлангийн дүнгүүдтэй тулган шалгахад зөрүү гараагүй.

Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 12-р сарын 20-ний өдрийн 116 тоот тогтоолоор гүний 5 худаг 47097,0 мянган төгрөгийн хөрөнгийг Зуун мод сумын ЗДТГазрын балансаас “Төв Чандмань –ДЭХГ” ОНӨҮГазрын газарт шилжүүлэх тогтоол гарсныг хэрэгжүүлээгүй хөрөнгийг орлого аваагүй байна. Энэ нь хүлээж авч буй 5 худгийн засварт шаардагдах материалын 1923,0

мянган төгрөгийн тооцоо шийдэгдээгүйгээс хүлээж аваагүй гэсэн тайлбар хийж байгаа нь тогтоол хэрэгжүүлээгүй байх үндэслэл болохгүй юм.

5. Мөнгөн хөрөнгө

Төв Чандмань ДЭХГ нь Төрийн сан, ХААН, Хас, Хадгаламж банкуудад харилцах дансуудтай. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулалт хийж харилцахын үлдэгдэл 28841,6 мянган төгрөгийг банк бүрээр авч үзэхэд Төрийн сангийн 140051410 тоот дансанд 1564,5 мянган төгрөг, ХААН банк Зуунмод ТТ 5721010026 тоот дансанд 9335,5 мянган төгрөг Төв аймаг Хас банк 30-р салбар, 5000202215 тоот дансанд 5042,8 мянган төгрөг, Хадгаламж банк 31000001851 тоот данс 8703,7 мянган төгрөг, Хас банкинд 671,9 мянган төгрөгийн үлдэгдлүүдийг баталгаажуулсан байна.

Мөнгөн кассаар 1040229,8 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 1049411,4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 3523,2 мянган төгрөгийн кассын үлдэгдэлийг бэлэн мөнгөний тооллого хийж баталгаажуулсан байна.

Мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон харилцахын үлдэгдэл ерөнхий дэвтэр, журнал, санхүүгийн тайланд үнэн зөв тусгагдсныг шалгахад данс хооронд андуурагдсан гүйлгээ 66200,0 мянган төгрөгийн гүйлгээ буцсан байна. Энэ нь Төрийн сангийн дансаас 2013 оны 11-р сарын 29-нд гарсан 50,0 сая төгрөгийн Шивээ овоо ХК –д шилжүүлсэн мөнгө 2013 оны 12-р сарын 02-нд буцаж орсон, мөн 2013 оны 5-р сарын 30-нд шилжүүлсэн 15,0 сая төгрөгийн НДШимтгэлийн мөнгө 2013 оны 05-р сарын 30-ны өдөр буцаж орсон, Хаан банкнаас 2013 оны 04-р сарын 10 нд ЭХХтөвд 1,2 сая төгрөг шилжүүлсэн нь 2013 оны 04-р сарын 11-ны буцаж орсон нийт 66,2 сая төгрөгийн гүйлгээг харилцах дансны хуулга болон мөнгөн хөрөнгийн журналд тусгаагүй байна.

6. Авлагын талаар

2013 оны эхэнд 242240.3 мянган төгрөг байсан бол оны эцэст 340482.1 мянган төгрөг болж 98241.8 мянган төгрөгөөр өссөн.

Авлагыг ангилж үзвэл төсөвт байгууллагаас авах авлага 126090,7 мянган төгрөгөөр, ААНБайгууллагаас авах авлага 13957,5 мянган төгрөгөөр өссөн бол айл өрхөөс авах авлага 5372,9 мянган төгрөг, бусад авлага 36433,5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт авлагын 340482,1 мянган төгрөгийн 217266,1 мянган төгрөг буюу 63,8% төсөвт байгууллагын, 68750,9 мянган төгрөг буюу 20,2 % нь ААНБайгууллагын, 28356,6 мянган төгрөг буюу 8,3% айл өрхийн , 26099.5 мянган төгрөгийн буюу 7.7 % нь бусад авлага эзлэж байна. Төсөвт байгууллагуудын 217266,1 мянган төгрөгийн авлага нь 16 байгууллага 6,8-77965,1 мянган төгрөгийн авлага байгаагаас нэрлэвэл Хүмүүн цогцолбор сургууль 77965,1 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс 41765,3 мянган төгрөг, Музей 34715,2 мянган төгрөг, цэцэрлэгүүд 27660,3 мянган төгрөг, 4,5-р сургуулиуд 16536,8 мянган төгрөг авлагатай байна. ААНБайгууллагын 68750,9 мянган төгрөгийн авлага нь 48 байгууллага 10,0-11690,7 мянган төгрөгийн авлагатай байгаагаас өндөр дүнтэйг нэрлэвэл Ихнаяд ХХК11690,7 мянган төгрөг, ҮЭХолбоо 10357,2 мянган төгрөг, Их хайрхан богд ХХК 7206,6 мянган төгрөг, МАН-ын хороо 6325,6 мянган төгрөг, Максимум ХХК 5556,7 мянган төгрөг, Эмэгтэйчүүдийн зөвлөл 4927,6 мянган төгрөг, Морь хангай 4523,0 мянган төгрөг нийт 50596,5 мянган төгрөг нийт авлагын 73,6 хувийг эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардал 130928,8 мянган төгрөг тусгасан нь тендерээр он дамжин хийгдэж байгаа ажлын урьдчилж хийсэн ажлын зардал 40555,8 мянган төгрөг, нөөцөлсөн оны эцсийн үлдэгдэл 10,68 мянган тн нүүрсэнд ноогдох тээврийн зардлыг 90373,0 мянган төгрөгийн тус тус бүртгэсэн байна.

7. Өглөгийн талаар

2013 оны эхэнд 718681,2 мянган төгрөгийн өртэй байсан бол оны эцэст 894886,5 мянган төгрөг болж 176205,3 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Богино хугацаат өр төлбөрийн 25,5 хувь буюу 228938,9 мянган төгрөг урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн нь хойшлогдсон борлуулалтаар 144927,7 мянган төгрөг, түүнд ноогдох НӨАТ 14492,8 мянган төгрөг,

тендерээр хийгдэж буй цэвэрлэх байгууламжийн дуусаагүй ажлын үлдэгдэл 73235,6 мянган төгрөг, Жишиг хороололын ахуй үйлчилгээний барилгын бохирын шугамын ажил 4124,0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус эзлэж байна. Хойшлогдсон борлуулалтын орлогоор төсөвт байгууллагуудын авлагыг орж ирэх нь тодорхой бус, найдваргүй үлдэгдэлийг бүртгэсэн байна. Байгууллага хоорондын тооцооны өглөгөөр тусгагдсан 665947,5 мянган төгрөгийн өглөгийг задлавал нүүрс нийлүүлэгч 5 байгууллагад төлөх нүүрсний болон тээврийн хөлс 401763,1 мянган төгрөг нь нийт өглөгийн 60,3 хувийг эзлэж байна. Мөн Аймаг хөгжүүлэх санд 110824,5 мянган төгрөг, Өндөр настны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 17218,2 мянган төгрөг, Гэр хороололыг хөнгөлттэй түлээ нүүрсээр хангах үйл ажиллагааны тооцоогоор 10439,9 мянган төгрөг, ХХОАТатвар 44590,2 мянган төгрөг, НӨАТатвар 31872,2 мянган төгрөг, суутган 1070,3 мянган төгрөгийн нийт 216015,3 мянган төгрөгийн өр нь нийт өрийн 32,4 хувийг эзлэж байна. Өглөгийн тооцоо нийлсэн актуудыг шалгахад 571629,9 мянган төгрөгийн өглөгөөс 8519,1 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актгүй байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

1. Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор Зуунмод сумын ЗДТГазрын балансаас тус байгууллагын балансад шилжүүлээ шийдвэрийг хэрэгжүүлээгүй хөрөнгийг орлого аваагүй байгаа учир албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аймгийн Аудитын газар аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Мөнгөн гүйлгээний журналыг харилцах данснуудын хуулгатай тулган шалгахад данс андуурагдсан буюу залруулагдсан 66200,0 мянган төгрөгийн орлого зарлагыг гүйлгээг тусгаагүй байсныг залруулаагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын гүйцэтгэл бүрд тус байгууллагын удирдлагын зүгээс эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн Аудитын газраас тус Төв Чандмань ДЭХГазрын санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.